

ДАРХАН-УУЛ АЙМАГ



“НЭГ МОД НЭГ ГЭР БҮЛ” ТӨСӨЛ

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ : “ШИНЭ ДАВАЛГАА МӨНХ ХӨЖГИЛ” НҮТББ




2026 он



Төслийн танилцуулга

2026.05.06

Төслийн нэр:	“Нэг мод нэг гэр бүл ” төсөл
Төслийн бүтэц	Дархан хотын Морин хуур цогцолбортой уулаа моджуулах
Хөтөлбөр хэрэгжүүлэгчийн байршил	Дархан сум 8-р баг Морин хуур цогцолбортой уулын зүүн хойд энгэрт хэрэгжүүлэнэ.
Төсөл санаачлагч	“Шинэ давалгаа мөнх хөгжил” НҮТББ
Төслийн үр шим хүртэгч	Дархан хотын гэр бүл иргэд
Төслийн санхүүжүүлэгч	Дархан –Уул аймгийн ЗДТГ, “Ногоон Дархан-2032” хөтөлбөр
Төслийн нийт төсөв	12.200.000 төгрөг
Төсөл хэрэгжүүлэх хугацаа	2026 оны 2-р улиралд



Холбогдох ажилтан: Тэргүүн Д.Золжаргал
Хаяг байршил, утас : Дархан сум 11-р баг,
13-р хороолол, 41-р байр, 403 тоот
Утас: 99103283
Facebook хаяг: Шинэ давалагаа клуб



“ШИНЭ ДАВАЛГАА МӨНХ ХӨГЖИЛ”

НҮТББ-Н ТАНИЛЦУУЛГА

1. Байгууллагын нэр: “Шинэ давалгаа мөнх хөгжил” НҮТББ
2. Регистерийн дугаар: 8109044
3. Үүсгэн байгуулагдсан он: 2013 он
4. Үйл ажиллагааны чиглэл: Гишүүдийнхээ үйл ажиллагаа дэмжих, залуучуудыг дэмжиж нийгмийн оролцоог нэмэгдүүлэх
5. Гишүүд дэмжигчдийн тоо : 500 гаруй гишүүд дэмжигчтэй

“Шинэ давалгаа мөнх хөгжил” НҮТББ нь анх 2013 оны 3-р сарын 13-нд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулна. Дархан хотын залуучуудаа дэмжиж, нийгэмд дуу хоолойг хүргэх , сургалт , эрүүл мэнд, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулж ирсэн. Мөн мод тарих тэрбум мод хөтөлбөрийг дэмжин Морин хуур цогцолболтой уулын зүүн хойд энгэрт моджуулах ажлыг зохион байгуулж 100 мод тарьж арчилж ургуулсан.

БИДНИЙ УРИА:

“СЭТГЭЕ ШИНЭЧИЛЬЕ ХӨГЖЬЕ”

АЛСЫН ХАРАА

*ДАРХАН ХОТЫН ГЭР БҮЛ БҮХЭН АЗ ЖАРГАЛТАЙ ЭРҮҮЛ НОГООН ИРЭЭДҮЙГ
БҮТЭЭХ*

ЭРХЭМ ЗОРИЛГО

*ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ , НОГООН ОРЧНЫГ БҮРДҮҮЛСЭН ЗАЛУУЧУУДАД ЭЭЛТЭЙ
ӨНДӨР ОРЛОГОТОЙ АЖЛЫН БАЙР ХАНГАЛТТАЙ ДАРХАН ХОТЫГ БҮТЭЭХЭД ХУВЬ
НЭМРЭЭ ОРУУЛАХ*



Төслийн тодорхойлолт:

Энэхүү төсөл нь гэр бүлийн үнэ цэн, хамтын ажиллагааг байгаль хамгаалах үйлстэй холбосон нийгмийн нөлөөллийн ажил юм. Дархан хотын оршин суугч гэр бүл бүр өөрийн нэрэмжит нэг модыг хотын суурьшлын бүсэд тарьж, түүнийгээ арчлан ургуулах замаар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Төслийн гол дүр төрх нь байгаль дэлхийгээ хайрлаж буй уламжлалт болон орчин үеийн хэв шинжийг хослуулсан монгол гэр бүл байх болно.

Төслийн үндэслэл:

- Хотын агаар ба орчны бохирдол: Дархан хот нь үйлдвэрлэлийн бүс тул агаар дахь тоос шороо, утааг багасгахын тулд ногоон зурвас зайлшгүй шаардлагатай.
- Уур амьсгалын өөрчлөлт: Дэлхийн дулаарал, цөлжилтийн эсрэг "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг орон нутгийн түвшинд бодит ажил болгох хэрэгцээ.
- Гэр бүлийн хүмүүжил: Хүүхэд залуучуудад багаас нь байгаль дэлхийгээ хайрлах, хөдөлмөрлөх дадлыг гэр бүлийн орчинд төлөвшүүлэх.

Төслийн зорилго:

Дархан хотын оршин суугчдын оролцоотойгоор хот суурин газрын экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, гэр бүлийн гишүүдийн дунд "Нэгдмэл зорилго - Ногоон ирээдүй" гэсэн үзэл санааг түгээн дэлгэрүүлэхэд оршино.

Гарах үр дүн:

Экологийн үр дүн: Дархан хотын ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдэж, тоосжилт буурч, хотын бичил уур амьсгал сайжирна.




Нийгмийн үр дүн: Гэр бүлийн халуун дулаан уур амьсгал бэхжиж, иргэдийн байгаль орчноо хамгаалах идэвх оролцоо дээшилнэ.

Тогтвортой байдал: Айл өрх бүр өөрийн тарьсан модоо хариуцан арчлах учраас модны ургалтын хувь өндөр (90%-иас дээш) байх боломж бүрдэнэ.

Хотын үзэмж: Хот суурин газрын өнгө үзэмж засагдаж, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдэнэ.



ТӨСЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦОО

№	Материалын нэр төрөл	Үзүүлэлт төрөл зүйл	Хэмжих Нэгж	Тоо, хэмжээ	Нэгж үнэ, төг	Нийт үнэ төгрөг	Шаардлагатай материалын зураг	Эх сурвалж
1	Хар шороон хөрс	Уулын хар шороо	м.куб	16	100.000	1.600.000		Хувь хүн
2	Элс	Элс	м.куб	10	60.000	600.000		Хувь хүн
3	Гацуур /	2-3 настай 1.0-1.5м өндөр	ш	40	250.000	10.000.000		https://www.facebook.com/profile.php?id=61561138701695
	Нийт дүн /төгрөг/					12,200,000		

Мод тарихтай холбоотой нэмэлт тээвэр, усалгаа, багаж хэрэгжсэл бусад зардал 5,0сая төгрөгийг бид өөрсдөөс санхүүжүүлнэ.

Төсөл бичсэн Шинэ давалгаа мөнх хөгжил НҮТББ ТЭРГҮҮН


Д.ЗОЛЖАРГАЛ



ШИНЭ ДАВАЛГАА МӨНХ ХӨГЖИЛ НҮТБ

Мод тарих талбайн зураг





ШИНЭ ДАВАЛГАА МӨНХ ХӨГЖИЛ НҮТББ

Өмнөх жилүүдэд манай ТББ-ийн гүшүүд дэмжигчдын тус талбайд мод тарьсан нь ургалт сайтай байна. Энэ арчилгаа сайн хийдэгтэй холбоотой юм.

